



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 6/24

Чингис хот

Л.Батсайханыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчийн газрын дарга Лхамын Батсайхан нь зургаан сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон тул 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөр дуусгавар болгон төрийн албанаас түр чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

С.Нямдаваа Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Цэцэгсүрэн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Н.Үнэнбат Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Л.Оюунтуяа Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч

3. Л.Батсайхантай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Л.Оюунтуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012464